

# Манмин Мэдээ

№ 81 2020 оны 2 сарын 23

## “Бурхан амласан зүйлээ зайлшгүй биелүүлдэг”

Хүсэл тэмүүлэлээр дүүрэн 2020он Манай сүмийн 4-н залбирлын сэдэв



2019оны 12-р сарын 29ний өдөр, Эзний өдрийн үдээс хойш мөргөлийн дараа шууд манай сүмийн жилийн хурал болж өнгөрлөө. Ерөнхий удирдагч И Сү жин пастор нь И Жей руг тэргүүн пасторыг орлож 2020онд бүх итгэгч нартайгаа хамт залбирч эрч хүчтэй урагшлах манай сүмийн 4н залбирлын сэдвийг танилцууллаа.

**1дэх залбирлын сэдэв. Босч гэрэлтэх өргөө сүм (Исаиа 60:1-3)**

Бурхан гэм нүгэл ёс бусаар дүүрч харанхуйлсаар байгаа энэ цаг үед гэрэл гаргах, гэрэлтэх өргөө сүмээр манай сүмийг босгож өгсөн юм. Одоог хүртэл телевиз болон хэвлэл мэдээлэлээр ариун сайн мэдээг түгээж гадаадын олон оронд нэгдсэн их цуглаан, сэргэлтийн цуглаан, зуны цуглаан зэрэг үйл ажиллагаануудаар дамжуулан маш их тэмдэг гайхамшиг илрэн гарч үй олон хүмүүсийг авралын замаар удирдсан юм.

Цаашид ч манай сүм Бурханы зөвшөөрч өгсөн одоогийн сорилтыг итгэлээрээ сайн ялан дийлж, илүү тод гэрэлтэх өргөө сүм болох юм. Ариун сайн мэдээ ба гал мэт Ариун Сүнсний эрх мэдлэт хүчээр бүх дэлхийг гэрэлтүүлэхэд бүх үндэстэн болон хаадууд манмины гэрэл рүү гарч ирэн

бүтээгч Бурханыг магтан алдрыг өргөх болно.

**2дох залбирлын сэдэв. Жинхэнэ сэтгэл төгс итгэл (Еврей 10:22)**

Бурхан энэ газарт хүн төрөлхтөний дасгалжуулалтаар дамжуулан дээд зэргийн үр жимс хураахыг хүсэж байгаа бөгөөд тэр үр жимс нь жинхэнэ сэтгэл, төгс итгэлийг бий болгосон итгэгч нар юм. Элдэв бохирдлоос нь цэвэрлэсэн давс бол хичнээн удаан хугацаа өнгөрсөн ч уг шинж чанараа алддаггүй шиг жинхэнэ сэтгэлтэй хүн нь ямар ч нөхцөл байдалд тэр сэтгэл хувирдаггүй юм. Ийм жинхэнэ сэтгэлтэй болж байж л төгс итгэлийг эзэмшдэг.

Энэ газар дээр дасгалжуулагдах явцад заримдаа сорилт шалгалтаар дамжуулан зүрх сэтгэл дэх хорон муу ил гарч, сатан диаволын нөлөөгөөр зовлон өвдөлтийг амсдаг ч тэгэх тусам халуун залбирч, зүрх сэтгэлээ шинэчилж, итгэлээ өсгөх нь итгэлийн амьдрал юм. Түүнчлэн хичээнгүйлэн Бурханы үг ба залбирлаар өөрийгөө зэвсэглэн илэрхий хорон мууг төдийгүй өөрөө ч ухаарахад хэцүү мөс чанар болон сэтгэлийн уг дах хорон мууг хүртэл үлдээлгүй хаясанаар Бурханы хүсэн хүлээсэн жинхэнэ үр жимсээр гарцгаая.

**Здах залбирлын сэдэв. Хайраар дүүрэн өргөө (1 Иохан 4:11-12; 1 Коринт 12:12)**

Их өргөө сүмийн барилгыг Бурхан Өөрөө төлөвлөж, тушаасаны дагуу цаг нь ирвэл зайлшгүй биелэгдэх бөгөөд тэгэхийн тулд эхлээд итгэгч нарын зүрх сэтгэл үнэнээр өөрчлөгдөж, цэвэрхэн үзэсгэлэнтэй, Бурханы баярлах өргөөг босгох ёстой.

Энд итгэгч нарын халуун үйлчлэл болон хайраар нэгдэх явдал зайлшгүй хэрэгтэй юм. Тэгэх л үед бидний мөргөл ба залбирлыг таалан хүлээн авах ба Их өргөө сүмийг байгуулах үе илүү ойртох юм.

**4дэх залбирлын сэдэв. Дахин бүтээх эрх мэдэлт хүч 100хувь (Езекиел 37:4-10)**

Дахин бүтээх хүч нөлөө нь хэдийн бүтээгдсэн зүйлийг солих юм уу, эвдэрч сүйдсэн зүйлийг сэргээж, шинэчлэх хүч нөлөөг хэлж байгаа юм. Дахин бүтээх хүч нөлөө

зайлшгүй хэрэгтэй шалтгаан нь гэмт хорон муугаар дүүрсэн энэ эцсийн үед нэг хүнийг ч гэсэн аврахын төлөө юм.

Өнөө үед Езекиелийн үзэгдэл шиг хувхай ясанд амь оруулж их цэрэг босгодог шиг яг л Бурханыг нүдээр харах мэт гайхамшигтай хүч нөлөөг мэдэрвэл олон хүмүүс итгэж хүлээж авахаас өөр аргагүй юм. Дахин бүтээх хүч чадал нь эцсийн үед амьдардаг хүмүүсийг шантралгүй яадаг ч гэсэн итгэлээрээ аврал авч ариун байдалд орохыг хүсч буй Бурхан Аавын хайрын илэрхийлэл юм.

Бурхан хүн төрөлхтөнийг мэдэх тул шантарч буцдаггүй нинжин сэтгэлтэй тул харамсдаггүй гэсэн үгээ зайлшгүй биелүүлдэг Эрхэм юм. Агуу зорилго дунд Манмин төв сүмийг байгуулж өнөөг хүртэл Өөрөө удирдсаар ирсэн Бурхандаа бүх талархал ба алдрыг өргөж, Бурханы өгсөн зөн хараа хүсэл мөрөөдөл биелэгдэх хүртэл Манмины үйлчлэл зогсохгүй юм.

## “Жижигхэн үйлчлэлээрээ сүмдээ дэм болохыг хүсэж байна”

Пак Жи мин сүмд үйлчлэгч (5-р Залуучуудын баг)

Би төв танхимд нэвтрүүлэгийн өрөөнд их мөргөлд оролцдог. Ариун хоор дуу болон магтаал дууг GCN телевизийн хоум пейжд нийтлэхийн төлөө хадмал үгийг оруулах, мөргөлийн бичлэг хийх, шаардлагатай тайлбар хадмалуудыг оруулах янзлах ажил хийдэг.

Оюутан байхдаа шууд нэвтрүүлэгийн бичлэг хийх боловсруулдаг байсан би аяндаа л залуучуудын багийн нэвтрүүлэгийн багт үйлчилдэг болсон юм. Үүгээр дамжуулан 2010он 4-р сараас төв сүмийн нэвтрүүлэгийн хэсэгт үйлчилдэг болоод хэдийн 10жил өнгөрчээ.

Тэр жилийн 6-р сард И Жей руг тэргүүн пасторын удирдсан ‘Онцгой эдгэрэл ивээлийн цуглаан’-ы цаг байлаа. Би нэвтрүүлэгийн өрөөнд цуглааны халуун уур амьсгалыг мэдэрч, өчүүхэн ч гэсэн үйлчлэлээр хамт байх боломж олсондоо сэтгэл хөдлөм цагийг өнгөрөөсөн юм.

Түүнээс хойш миний сэтгэл эрс өөрчлөгдсөн юм. Нэг долоо хоног өөрийн амьдарлаа эргэн харж, хагас сайн өдрийг аятайхан өнгөрөөс гэсэн бодолд автаж, тоомжиргүйхэн сүмд ирж очдог байсан итгэлийг минь сэрээх боломж байв. Индэрийн хажууд сургаал заагчийг ойрхон харах боломжтой бөгөөд хадмал тайлбарыг хийх учир сургаал үгэнд анхаарлаа хандуулж, тэр хэмжээгээр сургаалиар дамжуулан өгөгдөх ивээлийг бялхтал авах болсон юм.

Үнэндээ өчүүхэн үүрэг гүйцэтгэж байгаадаа ичдэг ч би хаана ч байсан яг ёстой газраа эргэлдэн үүргээ гүйцэтгэдэг жижиг араа болон сүмдээ хүч дэм болохыг хүсч байна.



**УБ Ариун баярт мэдээ чуулган**

**Мөргөлийн цагийн хуваарь**

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11:30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09:00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15:00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17:00

**залбирал цагийн хуваарь**

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

**Манай хаяг:**  
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

**Чуулганы утас:** 7000-3707

**Чуулганы ахлагчийн утас:** 8870-3712

**Е- шуудан:** power3712@gmail.com

## “Хэлээр дамжуулах Эзэний хайр, миний цуглаан учраас юм”

Ким Хён жүн (4-р залуучуудын баг)

Би 5жилийн өмнөөс эхлэн англи хэлний орчуулагчаар үйлчилж байгаа юм. Баасан гаригийн мөргөл, дахин амилалтын тоглолтын орчуулга, зуны цуглаан, ойн баяр гэх мэт сүмийн тэмдэглэлт баярын үйл ажиллагааны үеэр манай сүмд ирж буй гадаад зочдод тусалдаг үйлчлэл хийдэг.

Гадаадаас ирсэн зочдод Эзэнээс авсан ивээл ба хайр, И Жей руг тэргүүн пасторын итгэгч рүү хандах хайрын тухай дамжуулах үед тэр хүмүүс сэтгэл хөдлөж, аз жаргалтай байхыг би ч жаргалтай болдог.

Орчуулга хийхийн өмнө “Эзэн минь, Өнөөдөр ч миний дууг сонсч ивээл авч бүх итгэгч нар Бурхан Аавын халуухан хайрыг мэдрэхэд тусалж өгөөч” гэж заавал залбирдаг. Заримдаа Даниел Залбирлын үед биечлэн залбирч байгааг орчуулж өгөх үе байдаг ба энэ л миний орчуулгыг сонсоод суудалдаа толгой бөхийн сууж буй гадаад итгэгч нулимс дуслуулан хувцас руу урсаж байхыг хараад одоо ч мартаж чаддаггүй юм.

Би энэ ажлыг “миний сүм” учир өөриймсөгөөр Эзэнээс авсан ивээлийн ач хариулах сэтгэлээр хийдэг. Ажилд орсон ч одоо ч гэсэн орчуулгын үйлчлэлээ үргэлж хийж илүү их сэтгэлээ өргөхийг хүсдэг.

Энэ мэт эрхэм боломжыг өгсөн Бурхан Аавдаа болон үргэлж халуун гэр бүл мэт хүлээж авдаг багийн ажилтнууддаа баярлалаа.

## “Дуу хоолойгоор Эзэний ивээлийг дамжуулахад талархал ундардаг”

И Хён гён сүмд үйлчлэгч (1-р Канаан баг)

Би GCN телевизийн дуу оруулагчаар үйлчилдэг юм. Оюутан байхдаа сургуулийнхаа хөтөлгөөр ажиллаж байсан ба энэ нь Манмин магазин нэвтрүүлгийн багт ороод хэдийн жил өнгөрсөн байна.

Одоо би 7хоног болгоны баасан гаригийн мөргөлөөр гардаг Манмин магазин нэвтрүүлгийн байнгын дуу оруулагчын үүргийг гүйцэтгэж байна.

Дуу оруулах бичлэгийг хийж байхад маш их ивээл авдагч, юу юунаас илүү энэ үүргээ илүү сайн гүйцэтгэхий төлөө сэтгэлээ зориулан залбирч, Эзэний ивээлийг илүү хүсэн тэмүүлдэг нь хамгийн том ерөөл юм.

Хааяа ханиад хүрээд бичлэгт ороход хүндрэлтэй байдаг ч би хоолойгоороо ингэж үйлчлэнэ гэдэг тэр чигтээ Бурханы ивээл гэдгийг ухаарсан юм. Мөн төдийгүй амьдралын дунд талархал илүү их болж итгэгч нар ивээл авсан шүү гэхэд маш урам зориг авдаг.

Би Манмин төв сүмд ирээд Ариун Сүнснийг мэдэрч, хөлний үе мөч, өвдөгний өвчин хөндүүр, хүзүүний диск өвчнөөсөө И Жей руг тэргүүн пасторын залбирлаар цэвэрхэн эдгэрсэн юм. Тийм ивээл авсан учир талархах сэтгэлээр өгөгдсөн үүргээ гүйцэтгэж байна.

“Надад хүчийг өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна” (Филиппой 4:13) үгийн дагуу Бурханы хаанчлал болон алдарын төлөө хэрэглэгдсэн би болохын төлөө залбирч байна.

‘Сүнслэг хайр’ цуврал 11

## Хайр нь зөвт бус байдалд баярладаггүй

“Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй. Зохисгүй авирладаггүй, өөрийнхнийг эрдэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй, зөвт бус байдалд баярладаггүй.” 1 Коринт 13:4-6

И Жей руг тэргүүн пастор

Улс орон хөгжингүй байх тусам шударга зөв хүн амжилтанд хүрэх бололцоо их, магадлал өндөр байдаг бол эсрэгээрээ буурай улс оронд авилгал шударга бус явдал ноёрхсон байдагыг харж болно. Энэ мэт ёс бус байдалд автсан улс тэр чигтээ хөгжих эсвэл мөхөхтэй шууд холбоотой тул ‘Улс үндэстэнг мөхөлд хүргэх өвчин’ ч гэж нэрлэх нь бий. Хүн тус бүрийн хувийн амьдралд ч энэ ёс бус байдлын нөлөөнд автаж болохыг харж болдог.

‘Зөвт бус байдалд баярладаггүй’ гэдэг нь хайрын шинж чанарын дундаас ‘хорон мууг боддоггүй’ гэдэгтэй төстэй ч бас ялгаатай юм. ‘Хорон мууг боддоггүй’ гэдэг нь зүрх сэтгэлдээ хорон муугийн хэлбэрийг ч агуулахгүй байхын тулд ‘Зөвт бус байдалд баярладаггүй’ үйлсээр илрэн гарах таагүй үйлдэлд баярладаггүй бөгөөд хорон муу үйлдэлд нь оролцдоггүй юм.

### 1. Зөвт бус байдалд баярладаггүй хүн болохын тулд

Хангалуун, сайхан амьдардаг найзыгаа хараад атаа хорсол төрдөг. Тэрээр өөрийгөө гайхуулаад байгаа мэт санагдаж, үзэн ядаж эхлэдэг. Найз минь ийм сайхан амьдарч байхад би одоо юу вэ? бүтэлгүйтээсэй, дургүй хүрчлээ’ гэсэн бодолд автдаг Энэ бол хорон бодол юм. Тэгтэл тэр хангалуун найз нь луйвардуулаад дампуурч орхив. Энэ мэдээг сонсуут л ‘Ашгүй их онгилоод байсимаа’ гэхчлэн сэм баярладаг. Энэ ёс бус байдалд баярлаж буй хэрэг юм. Цаашлаад хорон муу

үйлсэд хүртэл оролцож байгаа бол идэвхитэйгээр ёс бус байдалд баярлаж зугаацаж буй хэрэг юм.

Тэгтэл хэн ч харсан буруу гэж мэдрэгдэхээр жирийн ёс бус зүйл байдаг. Жишээ нь шударгаар хөлс дуслуулан хөрөнгө хураах бус бусдыг хуурч мэхлэх юм уу хүч хэрэглэн булаах зэрэг буруу аргаар цуглуулах юм ч байдаг.

Хууль болон тогтсон дэг журмыг зөрчингөө өөрийн эрх ашгийг эрэлхийлэх тохиолдол юм. Хэнээс ч илүү шударга байх ёстой шүүгч хүн ч авлига авч зүй бус шийдвэр гаргаж гэмгүй хүнийг хилсдүүлж шийтгэвэд хэн ч харсан ёс зүйгүй явдал юм.

Мөн наймаа хийхдээ барааныхаа хэмжээг нь хасч худалдах юм уу, чанар муутай түүхий эдтэй хольж ашиг харах зэрэг нь юм. Бусад нь яах хамаагүй ашиг л олж байвал бодлоор дүүрэн байдаг. Юу нь зөв болохыг мэдсээр байж мэхэлдэг зан чанар юм. Энэ мэт бидний эргэн тойронд ингэж шударга бус орлого олох хуурдаг хүмүүс ямар их байна вэ? Тэгвэл та ямар хүн бэ?

Хэрэв та бүхэн өндөр албан тушаалтай бөгөөд таны дотны хүн тань ингэж зүй бус аргаар их хэмжээний мөнгө олж байгааг мэдсэн. Илэрвэл том шийтгэл хариуцлага хүлээх явдал юм. Гэтэл тэр найз чинь тийм ч бага биш мөнгө өгөөд хэсэг хугацаанд хараагүй юм шиг чимээгүй болоод өг гуйж ятган энэ удаагийн л ажил сайн бүтвэл дараа нь үнэхээр гомдоохгүй гэж байна. Яг одоо гэрт

томоохон юм хийхэд шаардлагатай мөнгө байв. Энэ хэцүү нөхцөлд орвол та бүхэн яах бол?

Мөн нэг өдөр хадгаламжийн дэвтрээ шалгаж үзтэл бодож байснаас илүү их үлдэгдэлтэй байв. Нягтлаад үзтэл хариуцсан ажилтаны хайхрамжгүй алдаанаас эндүүрэл гарч татвар суутгал нь суутгагдаагүй байв. Энэ үед ‘Ашгүй дээ угаасаа миний буруу тэр хүний хариуцлагагүй байдал ш дээ’ гэж баярлах уу?

Шастирын дэд 19:7д “Тийм учраас Эзэнээс эмээх сэтгэл та нарын дээр байх болтугай. Хийж буй зүйлдээ маш хянуур ханд. Учир нь бидний Бурхан Эзэн зөв шударга бус болон ялгаварлах байдал, хээл хахууль авах явдалд оролцохгүй юм хэмээв” гэсэн байдаг. Бурхан бол зөв шударга бөгөөд ёс бус байдал огт байхгүй юм. Хүний л нүдийг хариулах, хуурч болох ч, Бурханыг хуурах боломжгүй тул Бурханаас эмээх сэтгэлээр ч гэсэн цэгцтэй шударга амьдрах хэрэгтэй.

Абрахам Содом хотод амьдардаг үеэл дүүгээ дайнд өртөн боолоор баригдаад явахад үеэл төдийгүй Содом хотын хүмүүсийн эд хөрөнгийг бүгдийг нь буцааж өгсөн юм. Содомын хааны үүднээс Абрахам ямар ачтан билээ дээ? Хаан талархсанаа илэрхийлж, тэр хөрөнгийг Абрахамд өгч ачийг нь хариулах гэсэн ч эрс татгалздаг юм (Эхлэл 14:22-23).

Эхнэр Саргаа нас барахад ч газрын эзэн нь түүнд газраа оршуулаарай гэхэд ч авалгүй тохирсон үнээр нь газрыг худалдан авдаг. Хожим гарах

маргалдааныг зогсоох гэж тэр юм. Энэ нь түүнийг шударга бөгөөд зүй бус аргаар эд хөрөнгөжих сэтгэл байхгүйг илчилж байгаа юм.

Бурханыг хайрлаж, Бурханы хайрыг хүртдэг хүн эцэстээ бусдад хохирол учруулах юм уу, хууль дүрмийг зөрчих хүртэл өөрийн эрх ашгийг хайдаггүй юм. Зохистойгоор хөдөлмөрлөхөөс өөр зүйлийг хүсдэггүй гэсэн үг юм. Ёс бус байдалд баярладаг хүн тэр хэмжээгээр Бурхан руу хандсан, хүмүүсийг хайрлах хайр байхгүй учраас юм.

## 2. Ёс бус байдалд баярладаг хүний тавилан

Бурханы таалдаггүй ёс бус байдал гэдэг нь энгийн утгаас арай өөр юм. Хууль зөрчих юм уу бусдад хохирол учруулах төдийгүй Бурханы тушаалыг зөрчих нь хүртэл бүгд ёс бус явдал юм.

Зүрх сэтгэлийн хорон муу нь тодорхой хэлбэрээр илрэн гардаг гэм нүгэл бөгөөд энэ гэмүүдийн дундаас ялангуяа махан биеийн үйлсүүд хамаардаг. Өөрөөр хэлбэл үзэн ядалт, атаархал зэрэг хорон муу нь маргах, хүч хэрэглэх, залилах, аллага зэрэг тодорхой хэлбэр үйлдлээр гардаг юм. Тийм учраас ёс бус зүйлс үйлддэг хүн аврал авах хэцүү байдаг (1 Коринт 6:9-10).

Ёс бусыг хайрлаад эцэстээ мөхөл рүү явсан хүмүүсийн нэг болон Ахан юм. Тэрээр Египетээс гарагсдын 2-р үеийн хүн бөгөөд багаасаа Бурхан Өөрийн ард түмэнд үйлдсэн агуу зүйлүүдийг харж өссөн юм. Өдөр нь үүлэн багана шөнө нь гал баганаар замчилж байсныг санаж байгаа. Давалгаалж буй Иордан голын урсгал зогсож, бат бөх Иерихо цамхаг хоромхон зуур нурж

байгааг харсан байдаг.

Тухайн үед Иошуа Израйлийн удирдагч Иерихо цамхагийн ямар эд юмсыг бүү ав гэснийг Ахан сайн мэдэж байсан юм. Тэгтэл Иерихо цамхагаас гарч ирсэн эд юмсыг хараад шунал хөдөлж, ухаанаа алдаж орхидог.

Цөлд удаан хугацааны турш амьдарч шороо чулуутай хутгалдан нэг хэвийн амьдралдаа дассан түүнд Иерихо цамхагийн эд юмс нүдэнд нь яалт чгүй тусах хэмжээний байлаа. Үзэмжтэй сайхан гадуур хувцас гялалзах алтан, мөнгөн гулдмайг хараад Ахан Бурханы тушаалийг, Иошуагийн захиасыг мартан тэднийг авч нуув.

Аханы энэ үйлдлээс болж, Израйль дайнд ялагдаж хохирол амсдаг. Түүний улмаас Аханы энэ ёсбус байдал ил гарч, тэр болон түүний гэр бүлийнхэн чулуугаар шидүүлж үхдэг. Энэ чулуу овоо боссон газрыг хараагдсаны тэмдэг Агул хөндий гэдэг.

Мөн Балаам Бурхантай холбогддог хүн байсан юм. Нэгэн өдөр Моабын хаан Балак Балаам дээр ирэн Бурхан хамт байгаа Израйлийг харааж өгөөч гэж гуйдаг. Тэгтэл Бурхан Балаамд “Тэдэнтэй хамт бүү явагтун. Тэр ард түмэн ерөөгдсөн учир чи тэднийг харааж болохгүй” (Тооллого 22:12) гэсэн юм.

Балаам нь Бурханы үгийг сонсоод анхандаа Моабын хааны хүсэлтийг эсэргүүцсэн юм. Гэтэл хаан алтан маш их алт явуулан дахин гуйхад сэтгэл ганхаж эхэлсэн юм. Эцэстээ эд баялагт нүд нь харанхуйлсан тэрээр Израйль ард түмнийг занганд оруулах аргыг хаанд зааж өгсөн байдаг. Түүний үр дүн нь Израйльчууд хиймэл шүтээнд өргөсөн зүйлс идэж, түүндээ үйлчилсэнээр том гай гамшигт унаж

Балаам илдэнд цавчуулж өнгөрсөн юм. Энэ нь ёс бусыг хайрласнаас болж байгаа юм.

Хэрэв Бурханы хүүхэд итгэдэггүй хүнээс ялгарах юмгүй ёс бусыг үйлдвэл яах ёстой вэ? Мэдээжийн хайраараа залбирч өгч, үгийн дагуу амьдрахад нь туслах ёстой юм. Гэтэл ‘Би өөрийн тааваар тайван баймаар байна’ гээд ёс бусыг үйлддэг хүнд шохоорхох тохиолдол байдаг. Цаашлаад тийм ёс бус үйлдэлд нь хамт оролцдог бол Эзэнд хайртай гэж хэлэх боломжгүй юм.

Хайрт итгэгч та бүхэн, Аврагч Эзэн болсон Есүс ёс бусыг үйлддэг хүмүүсийг аврахын төлөө тэр аймшигт загалмайн зовлонг эдэлсэн юм (1 Петр 3:18). Ийм загалмайн хайраар аврал хүртсэн итгэгч нар Бурханы агуу хайрыг амссан тул зүгээр л ёс бусыг үйлдэхгүй түвшинг даван Бурханы үгийн дагуу амьдрах ёстой юм.

Тэгж байж итгэлийн өвөг болсон Абрахам шиг ёс бус байдалд баярладаггүй Бурханы жинхэнэ үр хүүхэд болон бүх зүйлдээ амжилтаар дүүрэн амьдрахыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

Mongolian

## Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

---

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот  
152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-818-7048  
<http://www.manmin.org/english>  
[www.manminnews.com](http://www.manminnews.com)  
e-mail: [manminninen@manmin.kr](mailto:manminninen@manmin.kr)  
Нийтлүүлэгч: Жаерок Лее


### Монгол Манмин Сүм

#### Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

#### Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00





## Дэлхийн өнцөг булан бүрт эдгэрлийн цуглаанаар дамжуулагдах эрх мэдэлт хүчний нөлөө!

Сар бүрийн сүүлийн баасан гаригийн цуглааны 2-р хэсгээр явагдаж буй эдгэрлийн цуглаанд И Жей руг тэргүүн пасторын залбирч өгсөн гар алчуур (Үйлс 19:11-12)-аар пасторуудын ерөнхий удирдагч И Сү жин пастор залбирал хийж өгөхөд Солонгосын орон нутаг төдийгүй интернет, GCN телевиз, юутубээр дамжуулан дэлхий даяар оролцон, эдгэрэл авч Бурхандаа алдрыг өргөж байна. Гадаадаас ирсэн зарим гэрчлэлүүдийг танилцуулъя.



Сандип ах дүү  
(18нас, Энэтхэг Гуракпур)

### “Муу сүнсэнд эзэмдүүлсэн эмэгтэй дүү минь хэвийн болсон”

Нэг жилийн өмнө миний эмэгтэй дүү Анита нь муу сүнсэнд эзэмдүүлж маш зовиуртай байлаа. Гэрийнхнээ харааж зүхэж, чангаар орилон маш их ууртай байлаа.

Энэ байдал гарч ирсэнд Хинди шашны хүмүүсийг дуудаж зан үйл хийлгэж, тэдний заасны дагуу хийсэн юм. Тэд нар удахгүй муу сүнс гарна гэж байсан ч огт дээрдсэн юмгүй дүү маань бүр байж болохгүй муухай үгээр гэрийнхнээ зовоож байлаа. Бүр амиа хорлох вий гээд гар хөлийг нь хүлдэг болсон юм. 2018оны 1-р сард нагац ахаасаа Есүс Христийн тухай, ‘GCNTV HINDI’ тухай мэдээ сонсч, Дели Манмин цуглааны хариуцагч Ким Сан хи пасторыг мэддэг болсон юм. Тэгээд дүүгээ бужигнуулаад ирэхэд утсаар Ким Сан хи пасторын гар алчуур (Үйлс 19:11-12)-р залбирал авахад нам гүм болдолг байлаа.

Үүний дараа манай гэр бүл ‘GCNTV

HINDI’-р дамжуулан И Жей руг пасторын ‘Загалмайн үг’ болон ‘Арван хууль’ гэсэн сургаалиудыг сонсч, тэр хугацаанд хиймэл шүтээн шүтэж байсан болон бусад олон гэмээ гэмшсэн юм. 2019оны 1-р сард хөршүүдтэйгээ юутубээр Манмин төв сүмийн баасан гаригийн эдгэрлийн цуглаанд шууд оролцож байтал, тэнд маш олон хүмүүс эдгэрч байгааг хараад манай дүү ч эдгэрэх юм байна гэсэн бат итгэл төрсөн юм. 2-р сард эдгэрлийн цуглаанаар дүүгээ эдгээхийн тулд хамтдаа сургаал сонсож, чин сэтгэлээрээ залбирсан юм.

Тэгээд 2-р сарын 22нд (орон нутгийн цагаар) эдгэрлийн цуглааны үеэр гар алчуураар залбирч өгсөн И Сү жин пасторын залбирлыг авах үед дүү минь гэмшиж, Ариун Сүнсний галыг авсан юм. Тэгээд муу сүнс зайлж урьдынх шигээ хэвийн эрүүл болсон юм. Халлелүяа.



### “Чих шуугих өвчин эдгэрч одоо сайн сонсдог болсон”

Женси Гарсиа итгэгч  
(30нас, Элсальвадор, Сунсунате)

2018 оны 12-р сарын сүүлээр ханиад хүрээд өндөр халуурч, бас чихээр тэсэхийн аргагүй хатгуулж өвдөж эхлэсэн юм. Түүнээс хойш зүүн чихний сонсгол муудаж, чих их дүнгэнэдэг болов. Миний сэтгэлд гомдоллох ба үзэн ядах сэтгэлээ эргэн харж хаяхын төлөө залбирч гэмштэл 1-р сарын эдгэрлийн цуглаанд оролцоод зүүн чихний өвдөлт болон чих шуугих байдал алга болж одоо сайн сонсдог болсон.



### “Хараа сайжирч самбар дээр бичсэн юм сайн харагддаг болсон”

Каталина Коредор эгч дүү  
(21нас, Колумба, Богота)

2018 оноос эхлэн ойрын хараа муудаж, хичээл дээр байхад багшийн самбар дээр бичсэн бичиг сайн харагдахгүй, холоос мэндэлж буй найзыгаа танихгүй байх зэрэг тавгүй байдал их байлаа.

1-р сарын хамгийн сүүлийн баасан гаригийн мөргөлд сууж сургаал сонсож, би өөрийн бардам байдлаа олж мэдэн гэмшиж, эдгэрлийн цуглаанд оролцон залбирал авсаны дараа самбар дээрх бичиг мэдээж сайн харагдаж, бүдэгхэн харагддаг байсан хүний нүүр тод сайн хардаг болсон.



### “Саажсан зүүн нүдний зовхи хэвийн болсон”

Тан бун лон итгэгч  
(37нас, Малайз, Пенан)

5-6 сарын өмнөөс зүүн нүдний зовхи саажиж эхлэсэн ба нэг нүд аниатай чигээр байдаг болсон юм. Эмнэлэгт үзүүлэх тархины мэдрэлтэй холбоотой үүдсэн асуудлаас болж ийм болсон гэж хэлсэн юм.

Эм уусан ч ямар ч нэмэргүй, хагалгаанд орох ёстой гэж байлаа. Тэгтэл 1-р сарын эдгэрлийн цуглаанл оролцоод залбирал авсаны дараа өдрөөс эхлэн гайхалтайгаар саажсан нүдний зовхи хэвийн болсон юм.



### “Сонсгол сэргэж, машины сигналын дуу сонсогддог болсон”

Киттифон Висалчай итгэгч  
(35нас, Тайланд, Бангкок)

Би төрөлхийн сонсголын бэрхшээлтэй хүн бөгөөд Нефисис (Олон орны дохионы хэлний сайт)-р дамжуулан Манмин төв сүмийн баасан гаригийн мөргөлд оролцож байлаа.

1-р сарын эдгэрлийн цуглаанд оролцож, эрх мэдэлт хүчтэй гар алчуураар залбирал авсаны дараа гайхамшигтай нь зүүн чихний минь сонсгол сэргэсэн юм. Одоо машины сигналыг сайн сонсдог болсон төдийгүй 1 жилийн турш өвдөж байсан зүүн хөлний өвчин хөндүүр оргүй алга болсон юм.



### “7н жилийн турш бөглөрсөн байсан нулимсны сүв нээгдсэн”

Сайто Жихэ сүмд үйлчлэгч  
(61нас, Япон, Ямагата)

7-н жилийн өмнө баруун нүдэнд асуудал гарч эмнэлэгт үзүүлсэн юм. Тэгтэл нулимсны сүв бөглөрсөн байна гэсэн юм. Эмч нулимс гарах ч хэвийн бус байдлаар гардаг болно. Бүрэн эдгэрэхгүй гэсэн юм.

Тэгээд 1-р сарын эдгэрлийн цуглаанд оролцож, залбирал авахад нүдэнд таатай мэдрэмжтэй сэрүү татаж, хааяа нулимс гарч, 2-р сарын эдгэрлийн цуглаанд оролцон төгс эдгэрсэн юм.